



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 8/544

Хэрлэн сум

“Invest khentii” хөрөнгө  
оруулалтын чуулганыг сурталчлахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших, иргэд аж ахуй нэгжийг дэмжих, аймаг орон нутагт шинэ хөрөнгө оруулалт татах, төсвийн орлогоо бие даан бүрдүүлэхэд санхүү, эдийн засгийн боломжийг бий болгох зорилготой “Invest Khentii” хөрөнгө оруулалтын чуулганыг хэвлэл мэдээллээр сурталчлахад 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

